



# Татварын талаарх илэн далангүй яриа

УИХ-д өргөн барьсан хүн амын орлогын албан татварын хуулийн төсөл



Хувь хүмүүсийн орлогод нөлөөлж буй хамгийн чухал хууль, тогтоомж нь хүн амын орлогын албан татварын хууль юм. Засгийн газар хүн амын орлогын албан татварын хуулийг илүү ойлгомжтой болгон, түүний нэр томъёо, заалтуудыг нэг мөр ойлгох зорилгоор шинэчлэн найруулаад байна. Үүнд, зарим хуучирсан заалтуудыг хасч, нэр томъёог тайлбарласан заалтыг тусгасан болно. УИХ-д өргөн бариад байгаа энэхүү хуулийн төсөл нь татвар төлөгч аж ахуйн нэгж, байгууллага болон хувь хүмүүсийн хооронд бий болоод байгаа татварын зөрүүтэй байдлыг арилгахад мөн чиглэсэн юм.

Одоо мөрдөж буй хууль болон өргөн барьсан хуулийн төсөлд тусгасан татварын хувь, хэмжээ, хөнгөлөлтийн заалтуудыг дор харьцуулан харуулав. Дараагийн дугаартаа татвар ногдуулах орлого болон хуулийн төслийн талаарх нэмэлт мэдээллийг нийтэлнэ.

Заалт	Одоо мөрдөж буй хууль	Өргөн барьсан хууль
Татварын хувь, хэмжээ	Татварын 3 хувь үйлчилж байна: <ul style="list-style-type: none"> <li>Эхний 2,400,000 төгрөгт 10%;</li> <li>2,400,001-4,800,000 төгрөгт 20%;</li> <li>4,800,000 дээш төгрөгийн орлогод 30%.</li> </ul>	Хувь нь өөрчлөгдөөгүй боловч орлогын босгыг 50 хувиар өсгөсөн: <ul style="list-style-type: none"> <li>Эхний 3,600,000 төгрөгт 10%;</li> <li>3,600,001-7,200,000 төгрөгт 20%;</li> <li>7,200,000 дээш төгрөгийн орлогод 30%.</li> </ul>
Татварын тусгайлан ногдуулах хувь, хэмжээ	Зарим орлогын төрөлд албан татварыг тусгайлан ногдуулна: <ul style="list-style-type: none"> <li>10% - Эрхийн шимтгэл; урлагийн тоглолт, спортын уралдаан, тэмцээний шагнал; гадаад оронд эмнэлэг болон урлаг, уран сайхан, эрдэм шинжилгээ, сурталчилгаа зэрэг оюуны үйлчилгээ явуулсан иргэний орлого; үндсэн ажлын газраас бусад газар ажил эрхэлж авсан цалин, адилтгах бусад орлого;</li> <li>15% - Хувьцааны ногдол ашиг, хувь хүртэгчийн орлого, хүүгийн орлого (2008 оноос хүчинтэй);</li> <li>10% - бооцоот болон тааварт тоглоом, хонжворт сугалаа;</li> <li>2% - үл хөдлөх хөрөнгө худалдсанаас олсон орлогын дүнгээр;</li> <li>3% - Аж ахуйн нэгж, байгууллага хувь хүнээс бараа, материал, түүхий эд худалдаж авахдаа дундын суутгал хийнэ;</li> <li>5% - шинжлэх ухаан, утга зохиол, урлагийн бүтээл зохиогч, шинэ бүтээл, оновчтой санал гаргагч, загвар зохион бүтээгч нарын шагнал болон адилтгах бусад шагналын 5,000,000 хүртэлх төгрөгийн орлого; 10% - 5,000,000 дээш төгрөгийн орлого;</li> </ul>	Зарим орлогын төрөлд албан татварыг тусгайлан ногдуулна: <ul style="list-style-type: none"> <li>10% - Эрхийн шимтгэл; спортын уралдаан, тэмцээний шагнал; гадаад оронд эмнэлэг болон урлаг, уран сайхан, эрдэм шинжилгээ, сурталчилгаа зэрэг оюуны үйлчилгээ явуулсан иргэний орлого; үндсэн ажлын газраас бусад газар ажил эрхэлж авсан цалин, адилтгах бусад орлого;</li> <li>15% - Хувьцааны ногдол ашиг, хүүгийн орлого;</li> <li>30% - бооцоот болон тааварт тоглоом, хонжворт сугалаа;</li> <li>2% - үл хөдлөх хөрөнгө худалдсанаас олсон орлогын дүнгээр;</li> <li>3% - Аж ахуйн нэгж, байгууллага хувь хүнээс бараа, материал, түүхий эд худалдаж авахдаа дундын суутгал хийнэ;</li> </ul>
Татварын хөнгөлөлт	Оршин суугч татвар төлөгчид жилийн 48,000 төгрөгийн татварын хөнгөлөлт эдэлдэг. Энэ нь жилийн 480000 төгрөгийн орлогыг татвараас чөлөөлж байгаатай адил юм.	Уг хөнгөлөлт хүчинтэй байх бөгөөд хэмжээ нь 84,000 төгрөг болж өсөх юм. Энэ нь жилийн 840,000 төгрөгийн орлогыг татвараас чөлөөлж байгаатай адил юм.

Энэхүү мэдээлэл нь татварын шинэтгэлийн талаар нийт ард иргэдийн санаа бодлыг сонсох зорилгоор Сангийн яам, Үндэсний Татварын Ерөнхий Газраас явуулж буй цуврал хэлэлцүүлгийн есдүгээр хэсэг юм. Та бүхэн уг цувралын электрон хувилбарыг "Нээлттэй засаг" вэб сайт ([www.open-government.mn](http://www.open-government.mn)), Сангийн яамны вэб сайт ([www.mof.pmis.gov.mn](http://www.mof.pmis.gov.mn)), ҮТЕГ-ын вэб сайт ([www.mta.mn](http://www.mta.mn))-аас үзэж, саналаа ирүүлж болно.